



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 11 сарын 25 одор

Дугаар 36.

Улаанбаатар хот

XXXVI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXXVI дугаар хурал 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 13:00 цагт Төрийн ордон дахь "Чингис хаан" танхимд 93.7 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар /Ковид19/-ын нехцел байдлын талаар;

Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

2. Улсын хэмжээнд гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Улаанбаатар хот болон орон нутагт хязгаарлалтын дэглэмд байгаа иргэдийг оршин суух газарт нь буцаах талаар авч хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний тухай;

Зам, тээврийн хөгжлийн яамны  
Төрийн нарийн бичгийн дараа С.Батболд,

3. Иргэдийг коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай уед шуурхай арга хэмжээ авах зорилгоор емчийн хэлбэр үл харгалзан вэрийн байршлыг илэрхийлсэн QR кодыг нэвтрүүлэх арга хэмжээний талаар;

Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ,

4. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,

Нийслэлийн онцгой комиссын дарга Д.Сумьяабазар,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Ж.Болд,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Аймгуудын засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга нар,

Эрүүл мэндийн улсын албаны шуурхай штабт;

1.1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Улаанбаатар хот болон орон нутагт хязгаарлалтын дэглэмд байгаа иргэдийг оршин суух газарт нь буцаах арга хэмжээг Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 146 дугаар тушаалаар батлагдсан түр журмын хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн шуурхай зохион байгуулах;

1.2. Түр журмын хүрээнд орон нутагт зорчих иргэдээс коронавируст халдвар /Ковид-19/-ын шинжилгээ авах ажлыг халдвар хамгааллын дэглэмийг сахиулж шуурхай зохион байгуулах;

1.3. Түр журмын хүрээнд орон нутагт зорчих иргэдийн шинжилгээ авах нэмэлт цэг байгуулан, байршил, ажиллах хугацааг тодорхой гаргаж иргэдийг мэдээллээр хангах, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;

Хоёр. Засгийн газрын гишүүн, ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ,

Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ нарт.

2.1. Иргэдийг коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, цааш тархаах эрсдэлийг зогсоох шуурхай арга хэмжээ авах, иргэдийн хеделгээнийг хянах зорилгоор шинээр апплийшин гаргахдаа тэр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа Эрүүл мэндийн яамны шуурхай удирдлагын [www.119.mn](http://www.119.mn) порталын "Бүртгэл цэс", татвар төлөгчдийн "ebarimt" апплийшин, "VMS" системийн давуу болон сул талуудыг судалж, шийдлийг гаргаж танилцуулах.

2.2. Хязгаарлалтын дэглэмийн үед иргэдийн хөдөлгөөнийг хянах зорилгоор худалдаа, үйлчилгээний байгууллага, гудамж, талбай, шалган нэвтрүүлэх цэг болон нийтийн тээврээр үйлчлүүлэх үед тухайн байршлыг тодорхойлсон QR кодыг уншуулж хэвшүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

Гурав. Засгийн газар, Улсын онцгой комиссын гишүүд,  
Нийслэл, Говьсумбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь,  
аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт;

3.1. Улсын хэмжээнд гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс хойш үргэлжлүүлэн сунгах эсвэл хэсэгчлэн сунгах болон бэлэн байдлын зэргийг бууруулах талаар шийдвэр гаргахаар судалж байгаа тул салбарын хэмжээнд үүссэн нехцэл байдал, хүндрэл бэрхшээл, гарах шийдэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа үндэслэл, тооцоо, судалгаатай боловсруулж, албан бичгээр 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 12:00 цагийн дотор Улсын онцгой комиссын ажлын албанд ирүүлэх;

Дөрөв. Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар,  
Цагдаагийн ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт;

4.1. Засгийн газраас тогтоосон чиглэлийн дагуу Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан шийдвэрийн дагуу Дотоод хэргийн их сургуулийн сонсогч, суралцагчдын сургалтын эхний жилийн амралтыг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд түр хойшлуулах, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг сахиулах үйл ажиллагаанд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэн татан оролцуулах;

Тав. Засгийн газрын гишүүд, Улсын онцгой комиссын гишүүд,  
агентлагын дарга нарт;

5.1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх серег нөлөөг бууруулах тухай хуулийн хугацааг сунгахтай холбогдуулан нэмэлт өөрчлөлт оруулах саналаа боловсруулж, тайлбар, үндэслэлийн хамт Улсын онцгой комиссын ажлын албанд 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор албан бичгээр ирүүлэх;

5.2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Засгийн газар, Улсын Онцгой комиссын хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт, гүйцэтгэлд дотоод хяналт шалгалтыг салбар тус бурдээ зохион байгуулж 2020 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн дотор биелэлтийг гаргаж, тайланг ирүүлэх;

Зургаа Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,


Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Т.Менхсайхан,


Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Наранцогт.

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр,

Дорноговь, Өмнөговь, аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт.

6.1. БНХАУ-аас тавьж буй саналыг судлан үзэж, дипломат шугмаар харилцан тохиролцож, Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудын ачаа тээврийн зохион байгуулалт, халдварт хамгаалалын дэглэмийг сайжруулж, үйл ажиллагааг жигдүүлэх;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  Я СОДБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА  Т.МӨНХДОРЖ